



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүхийн шинжилгээний албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/113/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.dornogovi.audit.mn

Дорноговь аймаг

2021 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Б.Уранбилэг

Утас: 70523020

Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3.Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа.....	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	14
Аудитын зөвлөмж.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	14
4. Менежментийн захидал	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16

1.Төрийн аудитын санал, дүгнэлт


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ
АЛБАНЫ ДАРГА, ЦАГДААГИЙН ДЭД
ХУРАНДАА Ш.ЦОЛМОН ТАНАА

2021.09.25 № 16/263
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шинжилгээний албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шинжилгээний албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

ДАНС	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	966,155.00	1,483,309.00
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	0.00	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
3121	Төгрөг	0.00	0.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	0.00
33	АВЛАГА	47,795.00	542,309.00
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	-	542,309.00
335	Бусад авлага	47,795.00	-
3351	Байгууллагаас авах авлага	47,795.00	-
34	УРЬДЧИЛГАА	-	375,300.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	375,300.00
35	БАРАА МАТЕРИАЛ	918,360.00	565,700.00
351	Түүхий эд материал	512,500.00	158,100.00
35130	Эм боох материал	512,500.00	158,100.00
354	Хангамжийн материал	405,860.00	407,600.00
35410	Бичиг хэргийн материал	-	27,600.00
35420	Аж ахуйн материал	380,000.00	380,000.00
35470	Бусад хангамжийн материал	25,860.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	114,971,644.04	122,826,690.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	114,971,644.04	122,826,690.07
392	Биет хөрөнгө	71,835,644.04	79,690,690.07
39201	Барилга, байгууламж	56,561,820.00	56,561,820.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,012,647.84)	(2,025,295.68)
39203	Авто тээврийн хэрэгсэл	19,800,000.00	22,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(19,800,000.00)	(20,133,333.32)
39205	Машин, тоног төхөөрөмж	55,193,891.24	65,821,491.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	(39,876,858.92)	(45,773,197.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,531,832.89	8,621,847.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,562,393.33)	(6,182,642.04)
393	Биет бус хөрөнгө	43,136,000.00	43,136,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	43,136,000.00	43,136,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	115,937,799.04	124,309,999.07
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0.00	26,500.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	26,500.00
413	Өглөг	0.00	26,500.00
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	(0.00)	-
4136	Бусад өглөг	0.00	26,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	26,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	115,937,799.04	124,283,499.07
51	Засгийн газрын хувь оролцоо	115,937,799.04	124,283,499.07
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	80,638,053.00	80,638,053.00
51101	Өмч: -Төрийн өмч	80,638,053.00	80,638,053.00
512	Хуримтлагдсан үр дүн	29,455,783.56	37,801,483.59
51210	Өмнөх үеийн үр дүн	29,455,783.56	29,455,783.56
51220	Тайлант үеийн үр дүн	-	8,345,700.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,843,962.48	5,843,962.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	115,937,799.04	124,309,999.07

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	199,479,900.00	250,164,345.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,394,000.00	23,964,584.99
120	Нийтлэг татварын бус орлого	9,394,000.00	23,964,584.99
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	9,394,000.00	23,964,584.99
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,394,000.00	8,835,600.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	15,128,984.99
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	190,085,900.00	226,199,761.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	187,406,900.00	226,199,761.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	187,406,900.00	208,595,800.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	17,603,961.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,679,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,679,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	207,044,296.80	241,818,645.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	207,044,296.80	241,818,645.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	205,225,399.80	240,942,037.80
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	151,919,794.00	174,874,053.84
210101	Цалин	91,878,675.00	108,457,653.75
210102	Нэмэгдэл цалин	47,147,089.00	53,405,257.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,894,030.00	13,011,143.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,997,254.00	7,000,000.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	1,026,870.00	-
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,970,384.00	7,000,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,185,576.00	13,293,079.00
210301	Гэрэл цахилгааны зардал	763,452.00	829,779.00
210302	Түлш, халаалтын зардал	3,949,024.00	4,063,300.00
210304	Байрны түрээс	8,473,100.00	8,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,190,882.00	13,063,133.00
210401	Бичиг хэргийн материал	1,968,650.00	1,412,450.00
210402	Тээвэр, шатахууны зардал	10,020,000.00	8,895,000.00
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	1,602,232.00	1,438,553.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	703,950.00	261,000.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	896,050.00	1,056,130.00
2105	Нормативт зардал	4,529,500.00	3,105,850.00
210501	Эм	4,529,500.00	3,105,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,578,800.00	635,450.00
210602	Тавилга	40,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,327,800.00	635,450.00
210604	Урсгал засвар	2,211,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	5,493,500.00	3,079,900.00
210702	Дотоод томилолтын зардал	5,493,500.00	3,079,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	714,040.00	18,616,633.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	164,000.00	18,101,261.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	160,000.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	200,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,040.00	49,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	20,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	86,272.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,616,053.80	7,273,938.96
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,616,053.80	7,273,938.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,818,897.00	876,608.16
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,818,897.00	876,608.16
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,818,897.00	876,608.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(7,564,396.80)	8,345,700.03
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(7,564,396.80)	8,345,700.03

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	199,479,900.00	235,035,361.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,394,000.00	8,835,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,394,000.00	8,835,600.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	9,394,000.00	8,835,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,394,000.00	8,835,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	190,085,900.00	226,199,761.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	187,406,900.00	226,199,761.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	187,406,900.00	208,595,800.00
131002	Засгын газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	17,603,961.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,679,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,679,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	197,699,900.00	235,035,361.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	197,699,900.00	235,035,361.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	195,881,003.00	234,158,752.84
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	152,499,451.00	175,368,567.84
210101	Үндсэн цалин	88,671,855.00	108,409,861.78
210102	Нэмэгдэл	48,563,596.00	53,947,562.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,264,000.00	13,011,144.03
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,125,754.00	7,000,000.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	1,364,777.00	-
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,760,977.00	7,000,000.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	13,238,576.00	13,668,379.00
210301	Гэрэл цахилгааны зардал	763,452.00	829,779.00
210302	Түлш, халаалтын зардал	3,949,024.00	4,063,300.00
210304	Байрны түрээс	8,526,100.00	8,775,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,968,882.00	12,908,873.00
210401	Бичиг хэрэг	1,400,000.00	1,354,450.00
210402	Тээвэр, шатахуун	9,300,000.00	8,895,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,598,882.00	1,438,553.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.00	585,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	870,000.00	635,870.00
2105	Нормативт зардал	3,999,300.00	2,963,900.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,999,300.00	2,963,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,955,000.00	552,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	800,000.00	552,500.00
210604	Урсгал засвар	1,155,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	5,000,000.00	3,079,900.00
210702	Дотоод албан томилолт	5,000,000.00	3,079,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,094,040.00	18,616,633.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	544,000.00	18,101,261.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	360,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,040.00	49,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	20,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	86,272.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,818,897.00	876,608.16
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,818,897.00	876,608.16
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,818,897.00	876,608.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,780,000.00	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,780,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,780,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	1,780,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,780,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,780,000.00)	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
	ДАНС	511.00	51,300.00	51210+51220	
C01	2019 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	37,502,053.00	3,361.02	13,961,599.19	51,467,013.21
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,502,053.00	3,361.02	13,961,599.19	51,467,013.21
C04	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
C05	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	9,910,683.47	9,910,683.47
C08	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	80,638,053.00	5,843,962.48	29,455,783.56	115,937,799.04
D01	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	80,638,053.00	5,843,962.48	29,455,783.56	115,937,799.04
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	80,638,053.00	5,843,962.48	29,455,783.56	115,937,799.04
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	8,345,700.03	8,345,700.03
D09	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	80,638,053.00	5,843,962.48	37,801,483.59	124,283,499.07

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	217,095,800.00	216,554,791.84	541,008.16	99.75
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	217,095,800.00	216,554,791.84	541,008.16	99.75
210	Бараа, үйлчилгээний зардал	217,095,800.00	216,554,791.84	541,008.16	99.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	175,428,000.00	175,368,567.84	59,432.16	99.97
210101	Үндсэн цалин	110,000,000.00	108,409,861.78	1,590,138.22	98.55
210102	Нэмэгдэл	50,164,000.00	53,947,562.03	(3,783,562.03)	107.54
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	15,264,000.00	13,011,144.03	2,252,855.97	85.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,000,000.00	7,000,000.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,000,000.00	7,000,000.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,813,300.00	13,668,379.00	144,921.00	98.95
210301	Гэрэл цахилгаан	850,000.00	829,779.00	20,221.00	97.62
210302	Түлш, халаалт	4,063,300.00	4,063,300.00	-	100.00
210304	Байрны түрээс	8,900,000.00	8,775,300.00	124,700.00	98.60
2104	Хангамж, бараа материалын зардал	12,940,500.00	12,908,873.00	31,627.00	99.76
210401	Бичиг хэрэг	1,361,600.00	1,354,450.00	7,150.00	99.47
210402	Тээвэр (шатахуун)	8,895,000.00	8,895,000.00	-	100.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,445,900.00	1,438,553.00	7,347.00	99.49
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	593,200.00	585,000.00	8,200.00	98.62
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	644,800.00	635,870.00	8,930.00	98.62
2105	Нормативт зардал	2,964,800.00	2,963,900.00	900.00	99.97
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,964,800.00	2,963,900.00	900.00	99.97
2106	Эд хогшил худалдан авах	593,200.00	552,500.00	40,700.00	93.14
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	593,200.00	552,500.00	40,700.00	93.14
2107	Томилолт, зочны зардал	3,088,700.00	3,079,900.00	8,800.00	99.72
210702	Дотоод албан томилолт	3,088,700.00	3,079,900.00	8,800.00	99.72
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,267,300.00	1,012,672.00	254,628.00	79.91
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	497,300.00	497,300.00	-	100.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	360,000.00	360,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	-	200,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,000.00	49,100.00	40,900.00	54.56
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	20,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	100,000.00	86,272.00	13,728.00	86.27
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	217,095,800.00	217,431,400.00	(335,600.00)	100.15
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	208,595,800.00	208,595,800.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	208,595,800.00	208,595,800.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8,500,000.00	8,835,600.00	(335,600.00)	103.95
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,500,000.00	8,835,600.00	(335,600.00)	103.95
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн
2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)
21	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	17,603,961.00	(17,603,961.00)
210	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	17,603,961.00	(17,603,961.00)
2108	Бараа, үйлчилгээний зардал	-	17,603,961.00	(17,603,961.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	17,603,961.00	(17,603,961.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	17,603,961.00	(17,603,961.00)
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	17,603,961.00	(17,603,961.00)
4	Засгын газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	17,603,961.00	(17,603,961.00)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээн Шүүхийн шинжилгээний албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга, цагдаагийн дэд хурандаа Ш.Цолмон танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 23-ноос 2021 оны 02 дугаар сарын 23-ны хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Уранбилэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Шүүхийн шинжилгээний албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 13ж/26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эрхэм зорилго:

Шүүхийн шинжилгээний алба нь “Шүүхийн шинжилгээ явуулах эрх зүйн боловсронгуй орчин, оновчтой зохион байгуулалт, баталгаатай арга зүй, техник-технологийн дэвшлийг бүрэн ашиглах нөхцөлийг бий болгон, хүний нөөцийн чадварлаг баг бүрдүүлснээр аливаа хэргийг шинжлэх ухаанч нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д зааснаар Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д "Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн" гэж заасны дагуу үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хууль эрх зүй:

- Төсвийн тухай хууль
- Шүүхийн шинжилгээний тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль

- Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль
- Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоолоор батлагдсан “Цагдаагийн албан хаагчийн төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Шүүхийн шинжилгээний албаны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй. Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаас сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг нийт зардлын 161,715.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 3,234.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзэж жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 241,818.6 мянган төгрөгийн 2 хувиар тооцож 4,836.4 мянган төгрөгөөр тооцов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Шүүхийн шинжилгээний албаны тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,855.1 мянган төгрөгөөр буюу 6.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа		375.3	375.3
Бараа материал	918.40	565.70	-352.70
Үндсэн хөрөнгө	114,971.60	122,826.70	7,855.10
Нийт хөрөнгө	115,937.80	124,310.00	8,372.20
Өр төлбөр		26.5	26.50
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	115,937.80	124,283.50	8,345.70
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	115,937.80	124,310.00	8,372.20

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 375.3 мянган төгрөг болж 375.3 мянган төгрөгөөр өссөн нь Замын-Үүд сумд байрладаг ажлын байрны түрээсийн төлбөрийг гэрээ байгуулсан 1 жилийн хугацаагаар бүрэн төлсөнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 565.7 мянган төгрөг болж 352.7 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант жилийн төлөв буурсантай холбоотой байна. Үнэ төлбөргүй хүлээн авсан болон шилжүүлсэн бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 122,826.7 мянган төгрөг болж 7,855.1 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүйгээр 3,000.0 мянган төгрөгийн автомашин, 12,717.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлэн авсантай холбоотой байна. Үнэ төлбөргүй шилжүүлсэн үндсэн хөрөнгө байхгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 26.5 мянган төгрөг болж 26.5 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь байгууллагад төлөх өглөг ба тайлант онд батлагдсан төсөв хүрээгүй учраас өглөг үүссэн байна. Өглөгтэй байгууллагатай өглөг, авлагын тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 124,283.5 мянган төгрөг болж 8,345.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 50,684.4 мянган төгрөгөөр буюу 25 хувиар өссөн байна. Өмнөх оноос Засаг даргын нөөц хөрөнгөөс шилжүүлсэн дэмжлэгийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 241,818.6 мянган төгрөгөөр буюу 17 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал өссөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 360,108.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 360,108.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 143,012.2 мянган төгрөгөөр бууруулж 217,095.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 217,095.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 208,095.8 мянган төгрөгийг улсын төсвөөс олгохоор, 8,500.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 208,595.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлогоос 8,835.6 мянган төгрөг нийт 217,431.1 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдэж 876.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Туслах үйл ажиллагааны орлогоос 8,835.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн нь төлөвлөсөн орлогыг 4 хувиар давуулан биелүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 216,554.8 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 17,603.9 мянган төгрөгийн дэмжлэг авч, байгууллагын байгууллагын дээврийн засварын ажлыг хийсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 54 мэдээллээс хугацаандаа оруулсан 47 мэдээлэл, 7 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 төлбөрийн актыг бүрэн барагдуулсан байна. Аудитаар өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	2,463.7					
Албан шаардлага							
Зөвлөмж	2	546.5					
Нийт дүн	5	3,010.2					

/мянган төгрөг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 143,639.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 141,686.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,953.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах таслан зогсоох 2 зөвлөмж хүргүүлээ.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тайлант онд аймгийн ЗД-ын нөөц хөрөнгөөс 17,603.9 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлэн барилгын дээврийн засварын ажлыг тендер зохион байгуулснаар зарцуулсан байна. Тус орлогыг бүртгэлд тусгахдаа улсын төсвөөс санхүүжих орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн санхүүжилтээр орлогын хүлээн зөвшөөрч тайлагнан баталгаажуулсныг аудитын явцад залруулав.
2. Тус байгууллагын 2020 оны оны 9-р сард 3,000.0 сая төгрөгийн үлдэх өртөгтэй автомашин шилжүүлэн авсныг элэгдэл тооцуулаагүй тайлагнасныг завсрын аудитаар залруулав.

3. Тайлант оны 3-р улирлын төсвийн гүйцэтгэлийн тайлан буруу, алдаатай байгаагаас бүх зардал гүйцэтгэлээр алдаатай байгаагаас хэтрэлт хэмнэлт нь мөн буруу тайлагнасныг залруулав.
4. Тайлант оны эхний 3 улирлаар буюу завсрын аудитаар 28 удаагийн ажил гүйлгээгээр 38,236.8 сая төгрөгийн урьдчилгаа цалин олгох үеийн бүртгэлийг авлагаар бус өглөгөөр бүртгэж хаасан байна. Мөн жилийн эцсийн байдлаар цалингийн бүртгэлийг үзэхэд 11 дүгээр сард цалингийн урьдчилгааг авлагаар бүртгэх байтал өглөгөөр бүртгэснийг залруулав.
5. Байгууллагын 3-р улирлын мөнгөн гүйлгээ, санхүүгийн үр дүнгийн тайланд урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг 162,263,5 сая төгрөгөөр үнэн зөв тайлагнасан боловч төсвийн гүйцэтгэлийн тайланд 136,5540.0 сая төгрөгөөр тайлагнасныг залруулав.
6. Санхүүгийн 3-р улирлын санхүүгийн байдлын тайлан баланслаагүй, алдаатай тайлагнасныг залруулав.
7. Тайлант оны 3-р улирлын төсвийн гүйцэтгэлийн тайлан бүхэлдээ алдаатай тайлагнагдсан байна. Мөнгөн гүйлгээний тайлантай уялдахгүй, холбогдох журналын бүртгэлээрх ажил гүйлгээтэй тохирохгүй байна. Мөн батлагдсан төлөвлөгөөг алдаатай оруулснаар төсвийн гүйцэтгэлийн тайлан алдаатай, хэтрэлт, хэмнэлийг буруу илэрхийлсэн байна. Жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайланг үзэхэд нийт 629.3 мянган төгрөгийн хэмнэлттэй байгаа ба энэ нь эд хогшил худалдан авах зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардлууд хэмнэгдсэн байна. Харин жилийн эцсийн тайланг үзэхэд батлагдсан төсөв, төсвийн хэлбэлзэл нь төсвийн гүйцэтгэлийн тайлангаас зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад залруулав.
8. Тайлант оны 3-р улирлын түрээсийн зардлыг авч үзэхэд сар бүр 700.0 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийн гэрээтэй боловч нийт 9 сарын мөнгөн гүйлгээний шилжүүлгийг үзэхэд 375.3 мянган төгрөг илүү шилжүүлснийг УТЗ-аар бүртгээгүйг залруулан бүртгэж, санхүүгийн тайланд тусгав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 1,953.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,953.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, таслан зогсоох 2 зөвлөмж хүргүүлээ.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1,953.1 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудалд байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Зардлын данстай холбоотой:*

- 1.1. Илрүүлэлт Тайлант онд бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн зүйлсийн зардлаас 65,7 мянган төгрөгийн программ хангамжийн төлбөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас байгууллагаас төлөх ХЧТА-ын тэтгэмжид 107,4 мянган төгрөгийг эдийн засгийн ангилал зөрчиж шилжүүлсэн байна. Энэ нь үнэн зөв байдал, толилуулга ба тодруулга, хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа ба Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал”-ыг зөрчиж байна.
- 1.2. Эрсдэл: Батлагдсан төсвийг зориулалт бусаар, үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулах.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал”-ын дагуу зарцуулах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Байхгүй

2. *Балансын данстай холбоотой асуудал*

- 2.1 Илрүүлэлт: Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлийг үзэхэд 2019 онд бүртгэлд тусгасан 1,780.0 мянган төгрөгийн проекторын ашиглах жилийг оруулаагүйгээс элэгдэл тооцоогүй байна. Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 2.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.
- 2.3 Өгсөн зөвлөмж: ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 7.1-д “...элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, ... эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж, шийдвэрлүүлнэ” гэж заасныг дагуу ашиглах хугацаа дууссан хөрөнгийн үнэ, ашиглах хугацааг тогтоох, шаардлага хангахгүй хөрөнгийг акталж устгах асуудлыг холбогдох албан тушаалтнаар шийдвэрлүүлж, ажиллах.
- 2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Байхгүй

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>ШША-ны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2021			САГ-ДГА-2021/113/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Шүүхийн шинжилгээний алба		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд аймгийн ЗД-ын нөөц хөрөнгөөс 17,603.9 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлэн барилгын дээврийн засварын ажлыг тендер зохион байгуулснаар зарцуулсан байна. Тус орлогыг бүртгэлд тусгахдаа улсын төсвөөс санхүүжих орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн санхүүжилтээр орлогын хүлээн зөвшөөрч тайлагнан баталгаажуулсан байна.	17,603.9	Аудитын явцад залруулав	Дарга, цагдаагийн дэд хурандаа. Нягтлан бодогч, дэслэгч	Ш.Цолмон Л.Соронзонболд
2	Тус байгууллагын авто тээврийн хэрэгслийн бүртгэлд үлдэх өртөггүй автомашин байгаагаас элэгдэл тооцох боломжгүй байна. Мөн 2020 оны оны 9-р сард 3.0 сая төгрөгийн үлдэх өртөгтэй автомашин шилжүүлэн авсныг элэгдэл тооцуулаагүй тайлагнасан байна.	3,000.0	Аудитын явцад залруулав	Дарга, цагдаагийн дэд хурандаа. Нягтлан бодогч, дэслэгч	Ш.Цолмон Л.Соронзонболд
3	Тайлант оны 3-р улирлын ТГТ тайлан буруу, алдаатай байгаагаас бүх зардал гүйцэтгэлээр буруу алдаатай байгаагаас хэтрэлт хэмнэлт нь мөн буруу тайлагнагдсан байна.	25,723.5	Аудитын явцад залруулав	Дарга, цагдаагийн дэд хурандаа. Нягтлан бодогч, дэслэгч	Ш.Цолмон Л.Соронзонболд
4	Тайлант оны эхний 3 улирлаар буюу завсрын аудитаар 28 удаагийн ажил гүйлгээгээр 38.2 сая төгрөгийн урьдчилгаа цалин олгох үеийн бүртгэлийг авлагаар бус өглөгөөр бүртгэж хаасан байна. Мөн жилийн эцсийн байдлаар цалингийн бүртгэлийг үзэхэд 11 дүгээр сард цалингийн урьдчилгааг авлагаар бүртгэх байтал өглөгөөр бүртгэсэн байна.	43,536.8	Аудитын явцад залруулав	Дарга, цагдаагийн дэд хурандаа. Нягтлан бодогч, дэслэгч	Ш.Цолмон Л.Соронзонболд
5	Байгууллагын 3-р улирлын мөнгөн гүйлгээ, санхүүгийн үр дүнгийн тайланд урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг 162.3 сая төгрөгөөр үнэн зөв тайлагнасан боловч төсвийн гүйцэтгэлийн тайланд 136.5 сая төгрөгөөр тайлагнасан байна. Аудитын явцад тайланг засварлав.	25,723.5	Аудитын явцад залруулав	Дарга, цагдаагийн дэд хурандаа. Нягтлан бодогч, дэслэгч	Ш.Цолмон Л.Соронзонболд

6	Санхүүгийн 3-р улирлын санхүүгийн байдлын тайлан баланслаагүй, алдаатай тайлагнасныг залруулав.	-	Аудитын явцад залруулав	Дарга, цагдаагийн дэд хурандаа. Нягтлан бодогч, дэслэгч	Ш.Цолмон Л.Соронзонболд
7	Тайлант оны 3-р улирлын ТГТ бүхэлдээ алдаатай тайлагнагдсан байна. Мөнгөн гүйлгээний тайлантай уялдахгүй, холбогдох журналын бүртгэлээрх ажил гүйлгээтэй тохирохгүй байна. Мөн батлагдсан төлөвлөгөөг алдаатай оруулснаар төсвийн гүйцэтгэлийн тайлан алдаатай, хэтрэлт, хэмнэлийг буруу илэрхийлсэн байна. Жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайланг үзэхэд нийт 629.3 мянган төгрөгийн хэмнэлттэй байгаа ба энэ нь эд хогшил худалдан авах зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардлууд хэмнэгдсэн байна. Харин жилийн эцсийн тайланг үзэхэд батлагдсан төсөв, төсвийн хэлбэлзэл нь төсвийн гүйцэтгэлийн тайлангаас зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад залруулав.	25,723.5	Аудитын явцад залруулав	Дарга, цагдаагийн дэд хурандаа. Нягтлан бодогч, дэслэгч	Ш.Цолмон Л.Соронзонболд
8	Тайлант оны 3-р улирлын түрээсийн зардлыг авч үзэхэд сар бүр 700.0 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийн гэрээтэй боловч нийт 9 сарын мөнгөн гүйлгээний шилжүүлгийг үзэхэд 375300 төгрөг илүү шилжүүлснийг УТЗ-аар бүртгээгүй, санхүүгийн тайланг буруу илэрхийлж баталгаажуулсан байна. Жилийн эцсийн тайланд урьдчилж төлсөн зардлаар бүртгэж тайлагнасан.	375.3	Аудитын явцад залруулав	Дарга, цагдаагийн дэд хурандаа. Нягтлан бодогч, дэслэгч	Ш.Цолмон Л.Соронзонболд
9	Тайлант онд бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн зүйлсийн зардлаас 65,7 мянган төгрөгийн программ хангамжийн төлбөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас байгууллагаас төлөх ХЧТА-ын тэтгэмжид 107,4 мянган төгрөгийг эдийн засгийн ангилал зөрчиж шилжүүлсэн байна.	173.1	Зөвлөмж өгөх	Дарга, цагдаагийн дэд хурандаа. Нягтлан бодогч, дэслэгч	Ш.Цолмон Л.Соронзонболд
10	Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлийг үзэхэд 2019 онд бүртгэлд тусгасан 1,780.0 мянган төгрөгийн проекторын ашиглах жилийг оруулаагүйгээс элэгдэл тооцоогүй байна.	1,780.0	Зөвлөмж өгөх	Дарга, цагдаагийн дэд хурандаа. Нягтлан бодогч, дэслэгч	Ш.Цолмон Л.Соронзонболд
ДҮН		143,639.6			